

ЖАЙКА-ийн Монгол дахь Төлөөлөгчийн газрын мэдээллийн хуудас. 2019 оны 11 сарын дугаар.

Тэргүүн мэдээ.

Шударга өрсөлдөөний орчинг бэхжүүлэх төслийн 2 дугаар шатны үндсэн бичиг баримтад (RD) гарын үсэг зурав.



11 сарын 14-ний өдөр ТХА-ны хүрээнд 2020 оны 1 сараас 2022 оны 12 сар хүртэлх хугацаанд хэрэгжих Шударга өрсөлдөөний орчинг бэхжүүлэх төслийн 2-р шатны үндсэн бичиг баримтад ЖАЙКА-ийн Монгол дахь Төлөөлөгчийн газрын дарга Э.Тамура болон Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөөх газрын дарга Б.Лхагва нар гарын үсэг зурав. 2015 оны 9 сараас 2018 оны 9 сар хүртэл хэрэгжсэн уг төслийн эхний шатанд японы Шударга худалдааны хорооны дэмжлэгээр ШӨХТГ-ын байцаагч нарыг чадавхжуулж, өрсөлдөөний хуулийн шинэчлэсэн найруулгын төсөлд зөвлөгөө өгч ажилласан байна. Төслийн 2 дугаар шатанд эхний шатны үр дүнг үндэслэн шинэчлэн найруулсан өрсөлдөөний хуулийг дагалдан өөрчлөгдөх журмуудын төслийг боловсруулахад дэмжлэг үзүүлэх, өрсөлдөөний хууль, болон холбогдох журмуудыг олон нийтэд сурталчлан таниулах, соён гэгээрүүлэхийн хамт ажилтнуудын чадавхийг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх юм.

Төслийн хэрэгжилт.

Сургуулийн барилгын ажил өрнөж байна. Улаанбаатар хотын бага дунд сургуулийн барилга барих төсөл



Улаанбаатар хотын (цаашид УБ гэх) зарим сургууль хоёр ба гурван ээлжээр хичээллэдэг хэвээр, сурч боловсрох орчныг хангалттай сайжруулж чадахгүй байгаа юм. Иймд ЖАЙКА 2018 оны 8 сараас буцалтгүй тусламжаар УБ хотод бага, дунд сургуулийн 4 барилга барьж эхлэн, сургалтын орчныг сайжруулахад чиглэсэн дэмжлэг үзүүлж байгаа юм. Уг 4 сургуулийн барилгыг цаашид сургуулийн барилгын загвар болохуйц байгаль орчинд ээлтэй, гамшгаас хамгаалах байр болгож ашиглахаар төлөвлөсөн байна. Барилгын ажил Монголын хатуу ширүүн байгалийн нөхцлийг үл ажран өрнөж байгаа бөгөөд 2020 оны намар ашиглалтад оруулахаар зорьж байна.

Барилгын салбарын хөдөлмөрийн аюулгүй байдлын менежментийн чадавхийг сайжруулах төслийн хүрээнд Япон Улсад сургалт зохион байгуулав.



Монгол Улсад хот суурин газрын барилгажилт эрчимтэй явагдахын зэрэгцээ барилгын талбай дээр үйлдвэрлэлийн осол их хэмжээгээр гарч байгаа нь тулгамдсан асуудал болоод байна. ЖАЙКА хөдөлмөрийн аюулгүй байдлын бүх төрлийн тогтолцоо бий болгох, чадавхи сайжруулах зорилгоор техникийн хамтын ажиллагааны хүрээнд Барилгын салбарын хөдөлмөрийн аюулгүй байдлын менежментийн чадавхийг сайжруулах төслийг хэрэгжүүлж байна. 2019 оны 10 сарын сүүлээр япон улсад зохион байгуулсан сургалтаар японы хөдөлмөрийн аюулгүй байдлын тогтолцоо болон барилгын талбар дахь практик ажиллагааны талаар мэдлэгтэй болох боломж олгов.

Цаашид энэхүү төслийн хүрээнд бүх төрлийн тогтолцоо бий болгох, сургалтын хөтөлбөр боловсруулахад энэ удаагийн сургалтад хамрагдсан хүмүүс харьцангуй идэвхи санаачлагатай оролцох болов уу.

Монгол Улсын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах чадавхийг бэхжүүлэх төслийн үр дүнг танилцуулах семинар боллоо.



2016 оны 11 сараас хэрэгжиж эхэлсэн ТХА-ны “Монгол Улсын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах чадавхийг бэхжүүлэх төсөл” 2019 оны 11 сард дуусч буйтай холбогдуулан 11 сарын 7-ны өдөр уг төслийн үр дүнг танилцуулах семинар болов. ОБЕГ, БХБЯ, БСШУСЯ зэрэг хамтран ажиллагч байгуулагуудаас төслийн үр болох монголын анхны гамшгаас хамгаалах цагаан ном, газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээний аргачлалын заавар, гамшгаас хамгаалах боловсролын гарын авлагын талаар танилцуулга хийв. Мөн нүүлгэн шилжүүлэх байршлын тухай мэдээллийг агуулсан олон зайн мэдээллийн сан, барилга байгууламжийн хүчитгэлийн ач холбогдлыг үзүүлсэн макет зэргийг танилцуулан, оролцогчдод төслийн үр дүнг цаашид тогтвортойгоор үргэлжлүүлэх боломжийг таницуулсан арга хэмжээ болов.

ЖАЙКА-ийн сайн дурын үйл ажиллагаа

2018 оны 2-р ээлжийн 5 сайн дурын гишүүн явцын тайлангаа танилцуулав.



Томилогдон ирснээс хойш 1 жил үйл ажиллагаагаа явуулж буй 2018 оны 2-р ээлжийн 5 сайн дурын гишүүн 11 сарын 11-ний өдөр явцын тайлангаа танилцууллаа. Тухайн өдрийн үдээс өмнө нь харьяа яам, агентлаг дээрээ жилийн хугацаанд явуулж ирсэн үйл ажиллагааныхаа талаар танилцуулж, ажлын талбар дээр ажиглагдаж буй асуудал, тэдгээрийг хэрхэн шийдвэрлэх талаар ярьсан юм. Энэхүү арга хэмжээг холбогдох яам, агентлагийн зүгээс “Бодит байдлын талаар мэдэх үнэтэй боломж” хэмээн өндрөөр үнэлсэн байна. Харин үдээс хойш нь ЖАЙКА-ийн Монгол дахь Төлөөлөгчийн газрын хурлын танхимд тайлангаа тавьж, бусад сайн дурын гишүүдтэйгээ үйл ажиллагааны туршлагаа хуваалцлаа. Тэднийхээ цаашдын үйл ажиллагаанд амжилт хүсье.

Сайн дурын гишүүдийн Боловсролын салбар зөвлөл МУБИС дээр семинар зохион байгуулав.



МУБИС-д гоо зүйн боловсрол болон хүүхэд төвтэй бүлгийн удирдлагыг хэрэгжүүлэх талаар заах арга зүй хангалттай хэмжээнд бий болоогүй байна. Монголд үйл ажиллагаа явуулж байгаа ЖАЙКА-ийн сайн дурын гишүүдийн үүсгэн байгуулсан Боловсролын салбар зөвлөл МУБИС-ийн сургалтын арга зүйг сайжруулах чиглэлд дэмжлэг үзүүлэхийг зорьж байгаа юм. Энэ удаа эхний алхам болгож “Дуу хөгжим”, “Биеийн тамир”, “Бүлгийн удирдлага” гэсэн сэдвээр семинар зохион байгууллаа. Хичээлийн завсар зайгаа ашиглан цаг гарган оролцсон багш, оюутнуудын зүгээс “Хүүхдэд сонирхолтой арга зүй байна” хэмээн өндрөөр үнэлсэн үр дүнтэй арга хэмжээ болов.



ЖАЙКА-ийн Сургалт Төгсөгчдийн Холбоо

Сургалт төгсөгч “Аж ахуйн нэгж байгууллагын санхүүгийн тайлангийн шинжилгээ, дүгнэлт” сэдвээр семинар зохион байгууллаа.



ЖАЙКА-ийн сургалтаар олж авсан мэдлэгээ бусдад түгээн дэлгэрүүлэх зорилгоор сургалт төгсөгчид жил бүр олон сэдвээр Follow up сургалт семинарууд зохион байгуулдаг. Энэ жилийн анхны семинарыг 2009 оны “Бизнесийн удирдлагын сургагч багш бэлтгэх сургалт”-ад хамрагдсан төгсөгч Л.Наранчимэг (МУИС-ийн БС-ийн Нягтлан бодох бүртгэлийн тэнхимийн профессор) “Аж ахуйн нэгж байгууллагын санхүүгийн тайлангийн шинжилгээ, дүгнэлт” сэдвээр зохион байгууллаа. Санхүүгийн тайланд шинжилгээ хийж үр дүнг удирдлагын шийдвэр гаргалтанд ашиглах ур чадварыг эзэмшүүлэх зорилготой энэхүү семинарт компаний удирдлагууд зэрэг нийт 50 хүн оролцлоо.

Бие даасан захиргааны хуулийн этгээд Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага.(ЖАЙКА)

Монгол дахь төлөөлөгчийн газар.

Бодь цамхаг, 7 давхар, Сүхбаатарын талбай 3, Улаанбаатар, Монгол улс

(Төв шуудан, шуудангийн хайрцаг: 682, Улаанбаатар 211213, Монгол улс)

Утас:+976-325939, 311329, Факс:+976-310845 / E-mail: mg_oso_rep@jica.go.jp

Web: www.jica.go.jp/mongolia/index.html / FB: [JICA Mongolia](https://www.facebook.com/JICA.Mongolia)